

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

1.1 Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт

Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс **0.8 хувиар өсч 27.5 их наяд төгрөгт хүрэв**. Тодруулбал, жилийн өөрчлөлтийн 7.1 нэгж хувийг гадаад валютын харилцах, 2.3 нэгж хувийг төгрөгийн харилцах, 1.7 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -10.0 нэгж хувийг төгрөгийн хадгаламж тус тус бүрдүүлжээ (Зураг 1-1).

Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 1.9 хувиар өсөхөд хувийн байгууллагын гадаад валютын харилцах өссөн нь голлон нөлөөлжээ. Харин иргэдийн төгрөгийн хадгаламж буурсан байна (Зураг 1-2).

1.2 Хадгаламж


Нийт хадгаламжийн хэмжээ 17.2 их наяд төгрөг байгаагаас 87.4 хувь буюу 15.0 их наяд

төгрөг нь иргэдийн, 12.6 хувь буюу 2.2 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж бүрдүүлж байна. Мөн нийт хадгаламжийн 26.9 хувь нь гадаад валютын хадгаламж байгаа бөгөөд байгууллагын хадгаламжийн 39.7 хувийг, иргэдийн хадгаламжийн 25.0 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна (Зураг 1-3).


1.3 Мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт

Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 26.7 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 790.3 тэрбум төгрөгтэй тус тус тэнцэж байна. M2 мөнгөний өсөлтийн 14.2 нэгж хувийг ДЦА, -13.5 нэгж хувийг ГЦА бүрдүүлжээ (Зураг 1-4).


Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 205.5 тэрбум төгрөгөөр өсөв.




Зураг 1-2: M2 мөнгө өмнөх сараас 1.9%-иар өсөв.



Зураг 1-3: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 2.3 их наяд төгрөгөөр буурчээ.



Зураг 1-4: M2 мөнгөний жилийн өсөлтөд ДЦА-ын өсөлт эерэгээр нөлөөлж байна.




Эх сурвалж: Монголбанк

2. БАНКУУДЫН ЗЭЭЛ

2.1 Зээлийн өсөлт


Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **13.7 хувиар өсөж 22.8 их наяд төгрөгт** хүрэв. Годруулбал, жилийн өсөлтийн 5.5 нэгж хувийг худалдааны, 4.4 нэгж хувийг хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээл, 1.1 нэгж хувийг ипотек, 1.0 нэгж хувийг боловсруулах үйлдвэрлэлийн, 0.7 нэгж хувийг барилгын, -1.7 нэгж хувийг уул уурхайн, олборлолтын салбар, үлдсэн 2.9 нэгж хувийг бусад салбар бүрдүүлж байна (Зураг 2-1). Харин өмнөх сартай харьцуулахад зээлийн үлдэгдэл 195.1 тэрбум төгрөг буюу 0.9 хувиар нэмэгджээ. Мөн зээлийн үлдэгдлийн 1.4 их наяд төгрөг буюу 6.4 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна.

Зураг 2-1: Зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.7 их наяд төгрөгөөр нэмэгджээ.



Тайлбар: *Хэрэглээ+хадгаламж барьцаалсан зээл

Зураг 2-2: Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 12.9 тэрбум төгрөгөөр өсөж, эргэн төлөгдсөн зээл 100.8 тэрбум төгрөгөөр буурчээ.




2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Банкууд тайлант сард 2,524.5 тэрбум төгрөгийн зээл олгож, 2,386.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна (Зураг 2-2).

2.3 Зээлийн чанар

Нийт зээлийн **5.1 хувь буюу 1,159.2 тэрбум төгрөг анхаарал хандуулах, 11.2 хувь буюу 2,557.6 тэрбум төгрөг чанаргүй зээл** байв (Зураг 2-3). Чанаргүй зээлийн 20.6 хувийг уул уурхайн 16.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн, 14.9 хувийг барилгын, 10.7 хувийг худалдааны, 7.2 хувийг санхүү, даатгалын үйд ажиллагааны салбарын, 6.0 хувийг цалингийн зээл тус тус эзэлж байгаа бөгөөд нийт чанаргүй зээлийн 10.5 хувь нь гадаад валютаар олгосон зээл эзэлж байна (Зураг 2-4).

Зураг 2-3: Чанаргүй зээл өмнөх сараас 51.2 тэрбум төгрөгөөр өсч 2,557.6 тэрбум төгрөгт хүрэв.



Тайлбар: *Үйл ажиллагаа явуулж буй 12 банкаар

Зураг 2-4: Чанаргүй зээлийн дийлэнх хувийг уул уурхай, боловсруулах, барилга, худалдааны салбарын зээл эзэлж байна.




Эх сурвалж: Монголбанк

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

2.4 Хувийн байгууллагын зээл

Хувийн байгууллагын зээл өмнөх сараас 0.3 хувиар буюу 28.9 тэрбум төгрөгөөр өсөж 10.8 их наяд төгрөгт хүрчээ. Тодруулбал өмнөх сараас 26.8 тэрбум төгрөгөөр тээвэр, агуулахын, 24.3 тэрбум төгрөгөөр санхүүгийн болон даатгалын, 16.8 тэрбум төгрөгөөр үл хөдлөх хөрөнгийн, 14.1 тэрбум төгрөгөөр боловсруулах үйлдвэрлэлийн, 11.6 тэрбум төгрөгөөр мэдээлэл холбооны салбарт олгосон зээл тус тус өсөж, 42.6 тэрбум төгрөгөөр худалдааны, 35.5 тэрбум төгрөгөөр уул уурхайн, 5.7 тэрбум төгрөгөөр үйлчилгээний бусад салбарт олгосон зээл тус тус буурсан байна. Мөн хувийн байгууллагад тайлант сард шинээр 1,175.1 тэрбум төгрөгийн зээл олгосны 10.4 хувь буюу 122.7 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл нь гадаад валютаар олгосон зээл байв (Зураг 2-6).

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээл бүрдүүлж байна.



Зураг 2-6: Тайлант сард хувийн байгууллагад худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт дийлэнх зээл олгогдсон байна.




*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд

2.5 Иргэдийн зээл

Иргэдийн зээл өмнөх сараас 1.3 хувиар буюу 154.0 тэрбум төгрөгөөр өсөж 11.6 их наяд төгрөгт хүрчээ. Сарын өөрчлөлтийг авч үзвэл, ипотек 65.7 тэрбум, хадгаламж барьцаалсан зээл 35.1 тэрбум, цалин 13.0 тэрбум, тэтгэвэр 23.2 тэрбум, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 13.9 тэрбум, уул уурхай 13.3 тэрбум төгрөгөөр тус тус өсөж, худалдаа 14.4 тэрбум, тээвэр агуулахын үйл ажиллагаа 5.8 тэрбум, малчны зээл 5.0 тэрбум, автомашины зээл 3.3 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна (Зураг 2-7). Тайлант сард иргэдэд 1,267.7 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 0.9 хувь нь гадаад валютаар олгожээ.

Зураг 2-7: Иргэдийн зээлийн үлдэгдлийн 41.0% (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 23.0%-ийг цалин, тэтгэврийн зээл бүрдүүлж байна.



Зураг 2-8: Тайлант сард иргэдэд олгосон зээлийн ихэнх хувийг хадгаламж барьцаалсан зээл болон цалин, тэтгэврийн зээл бүрдүүлж байна.



*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд

Эх сурвалж: Монголбанк

3. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙН ЗЭЭЛ


3.1 ЖДҮ эрхлэгчдийн зээлийн өсөлт

ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **1.4 хувиар буурч 5.6 их наяд төгрөгт хүрсэн** байна (Зураг 3-1). ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үлдэгдлийн 37.9 хувийг худалдаа, 12.4 хувийг барилга, 10.6 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 4.6 хувийг ХАА, 3.7 хувийг байр сууц, нийтийн хоолны үйлчилгээний салбарын зээл бүрдүүлж байна (Зураг 3-2).


Нийт ЖДҮ эрхлэгчдийн зээлийн 59.4 хувь буюу 3.4 их наяд төгрөгийг ЖДҮ эрхлэгч ААН-д (Зураг 3-3), 40.6 хувь буюу 2.3 их наяд төгрөгийг ЖДҮ эрхлэгч иргэдэд тус тус олгожээ.

Өмнөх сартай харьцуулахад ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үлдэгдэл 114.4 тэрбум төгрөгөөр буюу 2.1 хувиар өсжээ.

Зураг 3-1: ЖДҮ зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурчээ.



Зураг 3-2: ЖДҮ эрхлэгч ААН-ийн зээлийн үлдэгдлийн 29.2 хувийг, иргэдийн зээлийн үлдэгдлийн 50.5 хувийг худалдааны салбарын зээл бүрдүүлж байна.



Тайлбар: ААН болон иргэдийн ЖДҮ-ийн зээлийн бүтцийг харуулав


3.2 Зээл олголт

Тайлант сард ЖДҮ эрхлэгчдэд **344.0 тэрбум төгрөгийн зээл** олгосон нь өмнөх оны мөн үеэс **43.0 хувиар буурч**, өмнөх сараас **5.8 хувиар өсжээ**. Тайлант сард олгосон зээлийн 32.6 хувийг худалдаа, 6.8 хувийг барилга, 3.1 хувийг ХАА, 2.7 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 2.3 хувийг байр сууц, нийтийн хоолны үйлчилгээний салбарт тус тус олгосон байна.


3.3 ЖДҮ эрхлэгчдийн зээлийн чанар

ЖДҮ эрхлэгчдийн зээлийн 4.9 хувь нь анхаарал хандуулах, 12.0 хувь нь чанаргүй зээл байна. Тодруулбал, анхаарал хандуулах зээл өмнөх сараас 19.5 хувиар, чанаргүй зээл 2.4 хувиар тус тус өсжээ (Зураг 3-4).

Зураг 3-3: ЖДҮ эрхлэгч ААН-ийн зээлийн үлдэгдлийн 45.6 хувь нь дунд ААН-д ногдож байна.



Зураг 3-4: ААН-ийн зээлийн 15.7 хувь, иргэдийн зээлийн 7.4 хувь нь чанаргүй зээл байна.



Тайлбар: ААН болон иргэдийн чанаргүй ангиллын зээлийг салбараар харуулав

Эх сурвалж: Монголбанк

4. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


4.1 Ипотекийн зээлийн өсөлт

Ипотекийн зээл 2022 оны 9 дүгээр сарын байдлаар **106,828 зээлдэгчийн нийт 6,190.5 тэрбум төгрөг** байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар өсжээ. Тодруулбал, хөтөлбөрийн эх үүсвэрээр 82,168 зээлдэгчид 4,579.1 (МИК ОССК-д шилжсэн зээлийн үлдэгдэл 3,338.3) тэрбум төгрөгийг зээл олгожээ (Зураг 4-1).

4.2 Зээлийн чанар

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 97.6 хувь нь хэвийн, 0.9 хувь нь анхаарал хандуулах, 1.5 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн 71.7 хувийг банкууд өөрийн, 27.7 хувийг хөтөлбөрийн, 0.7 хувийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна (Зураг 4-2).

Зураг 4-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 13.5% байна.



Зураг 4-2: Өмнөх сараас анхаарал хандуулах зээл 1.9 тэрбум төгрөгөөр өсөж, чанаргүй зээл 1.2 тэрбум төгрөгөөр буурав.



4.3 Эх үүсвэр

Ипотекийн зээлийг эх үүсвэрээр задалж үзвэл, 73.8 хувь нь хөтөлбөрийн, 24.1 хувь нь банкуудын өөрийн, 2.1 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. Тайлант сард шинээр **1153 зээлдэгчид 121.8 (үүнээс хөтөлбөрийн хүрээнд 740 зээлдэгчид 69.4) тэрбум төгрөгийн** ипотекийн зээл олгожээ (Зураг 4-3).


4.4 Орон сууцны байршил

Нийт ипотекийн зээлийн 16.4 хувь буюу **1,012.8 тэрбум төгрөгийн зээл орон нутагт** ногдож байна. Орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 76.3 хувь нь хөтөлбөрийн, 22.7 хувь нь банкны өөрийн, 1.0 хувь нь бусад эх үүсвэрээр олгожээ (Зураг 4-4).

Зураг 4-3: Тайлант сард 121.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгожээ.



Зураг 4-4: Нийт зээлийн 16.4% буюу 1,012.8 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



Эх сурвалж: Монголбанк

¹ Орон нутгийн банкны салбараас олгосон зээл бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон зээл болно.


4.5 Ипотекийн зээлийн хүү

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар, өмнөх сараас 0.9 нэгж хувиар өсч 9.2 хувьд хүрсэн байна (Зураг 4-5).


4.6 Барьцаа хөрөнгө

Ипотекийн зээлээр борлуулагдсан орон сууцны 85.7 хувийг 80 хүртэлх м.кв талбайтай байр бүрдүүлж байна (Зураг 4-6).

Зураг 4-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 9.2 хувьтай байна.



Зураг 4-6: Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ талбайн хэмжээгээр




4.7 Орон сууцнууд ашиглалтад орсон оноор

Ипотекийн зээлээр борлуулагдсан орон сууцны 78.0 хувийг 2011 оноос хойш баригдсан орон сууц бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь нийт ипотекийн зээлийн 83.1 хувийг эзэлж байна (Зураг 4-7).


4.8 Зээлдэгчдийн орлогын тархалт

Өрхийн орлого нь 2.5 сая төгрөг хүртэлх иргэд нь нийт зээлдэгчдийн 68.4 хувийг, нийт зээлийн үлдэгдлийн 53.0 хувийг тус тус бүрдүүлж байна (Зураг 4-8).

Зураг 4-7: Ипотекийн зээлийн үлдэгдлийн 83.1 хувийг 2011 оноос хойш ашиглалтад орсон орон сууц бүрдүүлж байна.



Зураг 4-8: Ипотекийн зээлдэгчдийн 68.4 хувийг сарын өрхийн орлого нь 2.5 сая төгрөг хүртэлх иргэд бүрдүүлж байна.



Эх сурвалж: Монголбанк

5. ХҮҮ


5.1 Шинээр олгосон зээлийн хүү

Тайлант сард шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 14.7 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.4 хувьд хүрчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төгрөгийн зээлийн хүү 0.3 нэгж хувиар, гадаад валютын зээлийн хүү 1.6 нэгж хувиар нэмэгджээ (Зураг 5-1). Тодруулбал, иргэдэд олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар нэмэгдэж ЖДХ 14.9 хувь, хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээл 0.1 нэгж хувиар нэмэгдэж ЖДХ 14.7 хувьд хүрэв.

Зураг 5-1: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх сартай ижил түвшинд байна.



Зураг 5-2: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүний тархалт



5.2 Шинээр татсан хадгаламжийн хүү

Тайлант сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ 8.8 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 2.4 хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 0.7 нэгж хувиар өсжээ (Зураг 5-3).


5.3 Хүүгийн зөрүү

Шинээр татсан төгрөгийн хадгаламж болон шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүний зөрүү 5.9 нэгж хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар буурав (Зураг 5-4).

Зураг 5-3: Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурав.



Зураг 5-4: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх сараас 0.3 нэгж хувиар өсөв.




Эх сурвалж: Монголбанк


5.4 Хадгаламжийн үлдэгдлээрх хүү

Төгрөгийн хадгаламжийн үлдэгдлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өсөж 7.9 хувьд, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 2.3 хувьд хүрчээ. Тодруулбал, иргэдийн төгрөгийн хадгаламжийн ЖДХ 7.9 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 2.4 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн ЖДХ 8.0 хувь байна (Зураг 5-5). Үлдэгдлээрх нийт төгрөгийн хугацаатай хадгаламжийн хүү 9.3 хувь байгаа бол бүх төрлийн хугацаагүй хадгаламжид хүү тооцогдохгүй² байгаа болно (Зураг 5-6).

Зураг 5-5: Үлдэгдлээрх иргэдийн хугацаат хадгаламжийн ЖДХ төгрөгийнх 9.4 хувь, гадаад валютынх 2.9 хувь байна.



Зураг 5-6: Нийт төгрөгийн хадгаламжийн 15.4 хувь нь хугацаагүй байршиж байна.




5.5 Зээлийн үлдэгдлээрх хүү


Төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 15.3 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.0 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 15.8 хувь, гадаад валютынх 14.4 хувь, хувийн байгууллагын төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 14.6 хувь, гадаад валютын ЖДХ 9.9 хувь байна (Зураг 5-7).

Нийт энгийн³ зээлийн үлдэгдлийн 52.2 хувь нь 2 хүртэлх жилийн дотор төлөгдөж дуусах зээл байна (Зураг 5-8).

Зураг 5-7: Иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурчээ.



Зураг 5-8: Нийт энгийн зээлийн үлдэгдэл, хугацаагаар




Эх сурвалж: Монголбанк

² “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт “Цар тахлын үед банкны хугацаагүй хадгаламжид хүү тооцохгүй байхаар зохицуулсантай холбоотойгоор 2021.01.29-2022.12.31 өдрийг дуустал бүх төрлийн хугацаагүй хадгаламжид хүү тооцохгүй.


³ Гэрээнд заасан хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгогдсон зээл.

6. ИНФЛЯЦ


Зураг 6-1: Улсын жилийн инфляц 13.8 хувьтай байна.




Зураг 6-2: УБ хотын жилийн инфляц 14.0 хувьд хүрэв.



Зураг 6-3: Хүнсний барааны бүлэг УБ хотын жилийн инфляцын 4.2 нэгж хувийг бүрдүүлэв.



Зураг 6-4: Хүнсний бус барааны бүлэг УБ хотын жилийн инфляцын 9.9 нэгж хувийг бүрдүүлэв.



Эх сурвалж: ҮСХ

6.1 Улсын инфляц

Улсын хэмжээнд 2022 оны 9-р сарын байдлаар сарын инфляц -0.2 хувь, **жилийн инфляц 13.8 хувь** байна. Тодруулбал, 9.8 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 4.0 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна (Зураг 6-1).

6.2 Улаанбаатар хотын инфляц

Улаанбаатар хотын хэмжээнд 9-р сарын байдлаар сарын инфляц -0.3 хувь, **жилийн инфляц 14.0 хувь** байгаа бөгөөд үүний 4.2 нэгж хувийг хүнсний бараа, 9.9 нэгж хувийг хүнснээс бусад бараа бүрдүүлж байна. (Зураг 6-2).

6.3 Хүнсний барааны үнэ (УБ)


Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 17.8 хувь өсөж инфляцын 4.2 нэгж хувийг бүрдүүлжээ. Үүний 1.2 нэгж хувийг талх, гурил, будаа, 0.8 нэгж хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, 0.7 нэгж хувийг хүнсний ногоо, 0.4 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүн үлдсэн 1.1 нэгж хувийг бусад хүнс тус тус бүрдүүлж байна (Зураг 6-3).

6.4 Хүнсний бус барааны үнэ (УБ)


Хүнснээс бусад барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 39.7 хувь өсөж жилийн инфляцын 9.9 нэгж хувийг бүрдүүлжээ. Үүний 2.0 нэгж хувийг эм, тариа, 1.5 нэгж хувийг шатахуун, 1.7 нэгж хувийг хувцас, бөс бараа болон гутал, 1.3 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 0.7 нэгж хувийг гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа, 0.7 нэгж хувийг зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ, үлдсэн 2.1 нэгж хувийг бусад бараа үйлчилгээ бүрдүүлж байна (Зураг 6-4).

7. ХАНШ


Зураг 7-1: Төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өөрчлөлт
жилийн өсөлт %



Зураг 7-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт
жилийн өсөлт %



Зураг 7-3: Төгрөгийн рубльтэй харьцах ханшийн өөрчлөлт
жилийн өсөлт %



Эх сурвалж: Монголбанк

7.1 Төгрөгийн ам.доллартой харьцах ханш

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сарын эцсийн байдлаар 3333.02 төгрөгт хүрсэн нь **өмнөх сарын эцсээс 4.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар** суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 3257.10 төгрөг байв (Зураг 7-1).

7.2 Төгрөгийн юаньтай харьцах ханш


Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш **өмнөх сараас 0.05 хувиар чангарч, өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар** суларч 462.55 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 459.11 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 471.29 төгрөг байлаа (Зураг 7-2).

7.3 Төгрөгийн рубльтэй харьцах ханш


Төгрөгийн рубльтэй харьцах ханш сарын эцсийн байдлаар 57.34 төгрөгт хүрсэн нь **өмнөх сарын эцсээс 10.0 хувиар, өмнөх оны мөн үеэс 46.2 хувиар** суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 54.48 төгрөг байв (Зураг 7-3).

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. M2 мөнгөний сарын өсөлт




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа, секторын ангиллаар




Зураг 2.3. Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа, салбарын ангиллаар



Зураг 2.4. Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлтийн задаргаа, салбарын ангиллаар



Зураг 2.5. Тайланд сард шинээр олгосон, төлөгдсөн зээл




Зураг 2.6. Тайлант сард шинээр олгосон зээл, салбарын ангиллаар





Зураг 2.7. Анхаарал хандуулах, чанаргүй зээл

Зураг 2.8. Чанаргүй зээл салбарын ангиллаар




Зураг 2.9. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл, салбарын ангиллаар


Зураг 2.10. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбарын ангиллаар




Зураг 2.11. Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц, салбарын ангиллаар




Зураг 2.12. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.13. Орон нутгийн зээлийн үлдэгдэл




Зураг 2.14. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь, аймаг тус бүрээр




3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Ипотекийн зээл насны ангиллаар



Зураг 3.2. Тухайн сард нийслэл хотод олгогдсон ипотекийн зээл, дүүргээр



Зураг 3.3. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар



Зураг 3.4. Тухайн сард орон нутагт олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар

